



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/166

Номгон

Нийтийн орон сууцны барилгын ашиглалтын  
үйл ажиллагааг зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, Орон сууцны тухай хуулийн 15<sup>1</sup> дугаар зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор сумын Рашаант 10 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлалтай 125, 133, 135 дугаар байрнуудын ашиглалтын хугацаа дуусгавар болсон тул үйл ажиллагааг зогсоосугай.

2.Рашаант 10 дугаар багийн 125, 133, 135 дугаар байрнуудын ашиглалтыг зогсоосонтой холбогдуулан оршин суугч иргэдийн эрүүл, аюулгүй байдлыг хангах, байрнаас нүүлгэн шилжүүлэх, үнэн бодит мэдээллийг өгөх, нурааж, буулгах үед гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, оршин суугчдыг оруулахгүй байх арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга Цагдаагийн дэд хурандаа Д.Мөнгөнтулга, Онцгой байдлын газрын гал түймрийн хяналтын улсын байцаагч М.Төмөрчедөр, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Дэд бүтэц, барилга, орон сууцны бодлого хариуцсан мэргэжилтэн Т.Норовринчин, 10 дугаар багийн Засаг дарга Т.Баярмагнай нарт үүрэг болгосугай.

3.Нийтийн зориулалттай орон сууц барих ажлыг чанартай, гэрээнд заасан хугацаанд ашиглалтад оруулж ажиллахыг “Хаш гоёо” ХХК-ний захирал (Э.Мөнхдалай)-д, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Т.Хишигбаатар)-д тус тус даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310415